



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН
ХОРШООДЫН
2024 ОНЫ ГУРАВДУГААР
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР

УЛААНБААТАР ХОТ

АГУУЛГА

НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	3
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	10
ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	11
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	11
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	13
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	13
3.4 Зээлийн чанарын талаар.....	14
ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	17
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	17
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	18
4.3 Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн талаар.....	18
4.4 Санхүүгийн бус өр төлбөр.....	19
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	20
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	20
ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА	21
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	21
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	21
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	22
ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	23
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	23

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024.11.11


Улаанбаатар хот

НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2024 оны 3 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 183 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 ХЗХ буюу 4.7 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 49.7 хувь буюу 91 ХЗХ орон нутагт, 50.3 хувь буюу 92 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

График 1: ХЗХ-дын тоо (хот, орон нутгаар)



ХЗХ-дын тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй буурсан боловч санхүүгийн болон статистик үзүүлэлтүүд харьцангуй тогтвортой байгаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг 4 улирал дараалан хангаагүй, өөрийн хөрөнгөгүй болсон,

хоршоологчдын өмчгүй болж үйл ажиллагаа доголдсон ХЗХ-дын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой байна.

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 2 ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 8 ХЗХ-ны 58 сонгуульт гишүүн (давхардсан тоогоор), 3 гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, 4 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2020	2021	2022	2023	2024.III
ХЗХ-ны тоо	249	209	196	191	183
Шинээр олгосон	14	-	7	3	2
Хүчингүй болгосон	26	40	20	8	10
Түдгэлзүүлсэн	23	12	13	12	6
Сэргээсэн	6	1	3	1	2
ТЗ-ийн хугацаа сунгасан	49	85	62	-*	-*

*Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд 2023.01.06-ны өдөр оруулсан өөрчлөлтийн дагуу ХЗХ-ны тусгай зөвшөөрөл хугацаагүй болсон.

1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2024 оны 3 дугаар улирлын байдлаар 183 ХЗХ 61 салбар, 800 ажилтан, 74,847 гишүүн (74,536 иргэн, 311 хуулийн этгээд)-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотод 92 ХЗХ Багахангай дүүргээс бусад дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 ХЗХ буюу 8.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд төвлөрөл хамгийн их байна.

Монгол Улсын 21 аймагт 91 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлт ороогүй байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 2: ХЗХ-дын тархалт



Зураг 1: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Зураг 3: ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл

2024 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,198 буюу 4.5 хувиар өсөж 74,847-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 54.1 хувь буюу 40,480 нь эмэгтэй, 0.4 хувь буюу 311 нь хуулийн этгээд, үүний 36.7 хувь буюу 114 нь эмэгтэй удирдлагатай байна.



НИЙТ ГИШҮҮД
74,847



Хуулийн этгээд 311




Хувь хүн 74,536



Эмэгтэй гишүүн 40,480

Нийт гишүүдийн 54.0 хувь буюу 40,442 гишүүн Улаанбаатар хотын ХЗХ-нд бүртгэлтэй бол 46.0 хувь буюу 34,405 гишүүн орон нутгийн ХЗХ-нд бүртгэлтэй байна.

График 2: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт (хот, орон нутгаар)



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурсан ч гишүүдийн тоо 2021 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өссөн бол 2023 оны 3 дугаар улирал хүртэл дунджаар 2.8 хувиар буурч, тайлант хугацаанд өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Нийт 183 ХЗХ-ны 31.7 хувь буюу 58 ХЗХ 20-100 гишүүнтэй, 51.4 хувь буюу 94 ХЗХ 101-500 гишүүнтэй, 9.3 хувь буюу 17 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 7.7 хувь буюу 14 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна. 1,001-ээс дээш гишүүнтэй ХЗХ-дын 57.1 хувь буюу 8 ХЗХ Улаанбаатар хотод, 42.9 хувь буюу 6 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд (интервалаар)	ХЗХ-ны тоо	Гишүүдийн тоо	Нийт гишүүдэд эзлэх хувь
20-100 гишүүнтэй	58	3,262	4.3%
101-500 гишүүнтэй	94	21,620	28.9%
501-1,000 гишүүнтэй	17	12,124	16.2%
1,001-ээс дээш гишүүнтэй	14	37,841	50.6%
Нийт	183	74,847	100.0%

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 14 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 50.6 хувийг эзэлж байна.

График 3: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



1.4 Бодлого, зохицуулалтын орчин

Хууль, эрх зүйн орчин

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.4 дэх заалтын хэрэгжилт

- Хуульд заасны дагуу 2023 оны тайланг аудитаар баталгаажуулж ирүүлбэл зохих 180 ХЗХ-оос тайланг улиралд 86.7 хувь буюу 156 ХЗХ жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэж Хороонд ирүүлсэн.

“Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавих нөхцөл, шаардлага”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтын хэрэгжилт

- Бүх гишүүдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд зарлан хуралдуулж, хурлын материалыг Хороонд ирүүлэх 180 ХЗХ-ны 97.2 хувь буюу 175 ХЗХ хууль болон нөхцөл, шаардлагаар хүлээсэн үүргийг биелүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

- ХЗХ-д Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй шаардлагатай мэдээллийг өгөх, авах гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 183 ХЗХ-ны 59.0 хувь буюу 108 ХЗХ зээлийн мэдээллийн санд хамрагдаж, үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. Үүнээс 52.8 хувь буюу 57 ХЗХ нийслэлд, 47.2 хувь буюу 51 ХЗХ орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

- 2024 оны 3 дугаар улиралд нийт ХЗХ-дын 7.1 хувь буюу 13 ХЗХ Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 19,159,617.37 мянган

төгрөгийн 201 гүйлгээг мэдээлсэн бөгөөд сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

- 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 88 ХЗХ 42,149.7 мянган төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 85 ХЗХ 98.3 хувь буюу 41,426.2 мянган төгрөгийг СЗХ-ны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Бүгд Найрамдах Кени Улсын Найроби хотод 2024.07.19-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагчдын зөвлөл (ICURN)-ийн ээлжит хуралд Хадгаламж, зээлийн хоршооны газрын төлөөлөл оролцож уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дасан зохицоход зохицуулалтын байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа талаар АНУ-ын Мэрилэнд муж болон Сейшэлын арлын хадгаламж, зээлийн хоршоодын зохицуулагч нартай туршлага хуваалцах хэлэлцүүлэгт модератороор оролцсон.

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 183 ХЗХ-оос 2024 оны 3 дугаар улирлын тайлангийн нэгтгэлд 7 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан болно.

2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 3: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	183	100.0%	92	50.3%	91	49.7%
Нийт гишүүдийн тоо	74,847	100.0%	40,442	54.0%	34,405	46.0%
Эрэгтэй	34,056	45.5%	17,005	49.9%	17,051	50.1%
Эмэгтэй	40,480	54.1%	23,199	57.3%	17,281	42.7%
Гишүүн хуулийн этгээд	311	0.4%	238	76.5%	73	23.5%
Эмэгтэй удирдлагатай	114	36.7%	82	71.9%	32	28.1%
Гишүүдийн насжилт	74,536	100.0%	40,204	53.9%	34,332	46.1%
18-35 насны	19,095	25.6%	10,641	55.7%	8,454	44.3%
36-45 насны	22,721	30.5%	12,325	54.2%	10,396	45.8%
46-55 насны	17,857	24.0%	9,372	52.5%	8,485	47.5%
56-аас дээш	14,863	19.9%	7,866	52.9%	6,997	47.1%
Гишүүдийн боловсрол	74,536	100.0%	40,204	53.9%	34,332	46.1%
Дээд	33,405	44.8%	22,454	67.2%	10,951	32.8%
Тусгай дунд	11,393	15.3%	6,777	59.5%	4,616	40.5%
Бүрэн дунд	18,356	24.6%	8,864	48.3%	9,492	51.7%
Дунд	8,302	11.1%	1,872	22.5%	6,430	77.5%
Бага	3,080	4.1%	237	7.7%	2,843	92.3%
Нийт ажилтнуудын тоо	800	100.0%	362	45.3%	438	54.8%
Үүнээс: Эмэгтэй	562	70.3%	253	45.0%	309	55.0%
Санхүүгийн програмтай	94	51.4%	37	39.4%	57	60.6%
Монголбанкны СМА-нд 20 сая төгрөгөөс дээш бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	13	100.0%	11	84.6%	2	15.4%
Гүйлгээний тоо	201	100.0%	189	94.0%	12	6.0%
Гүйлгээний дүн (мян.төг)	19,159,617.37	100.0%	18,638,159.27	97.3%	521,458.10	2.7%
Монголбанкны СМА-нд сэжигтэй гүйлгээг мэдээлсэн ХЗХ-дын тоо	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Сэжигтэй гүйлгээний тоо	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Сэжигтэй гүйлгээний дүн (мян.төг)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00

2024 оны 3 дугаар улиралд нийт ХЗХ-дын 7.1 хувь буюу 13 ХЗХ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-д заасны дагуу Монголбанкны СМА-нд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний нийт 19,159,617.37 мянган төгрөгийн 201 гүйлгээг мэдээлсэн байна. Дээрх гүйлгээний дүнгийн 97.3 хувь буюу 18,638,159.27 мянган төгрөгийн 189 гүйлгээг Улаанбаатар хотын 11 ХЗХ, 2.7 хувь буюу 521,458.10 мянган төгрөг бүхий 12 гүйлгээг орон нутгийн 2 ХЗХ мэдээлсэн. Тайлант улирлын байдлаар сэжигтэй гүйлгээ гараагүй байна.

Нийт ХЗХ-дын 51.4 хувь буюу 94 ХЗХ санхүүгийн програм хангамжтай байна. Нийт 800 ажилтны 54.8 хувь буюу 438 нь орон нутгийн ХЗХ-нд, 45.3 хувь буюу 362 нь Улаанбаатар хотын ХЗХ-нд ажиллаж байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
ХЗХ-дын тоо	183	100.0%	92	50.3%	91	49.7%
Нийт хадгаламжийн үлдэгдэл	239,661,339.36	100.0%	188,132,942.73	78.5%	51,528,396.63	21.5%
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	44,944	100.0%	24,358	54.2%	20,586	45.8%
Иргэн	44,881	99.9%	24,326	99.9%	20,555	99.8%
<i>Эмэгтэй</i>	24,743	55.1%	13,084	53.7%	11,659	56.6%
Хуулийн этгээд	63	0.1%	32	0.1%	31	0.2%
<i>Эмэгтэй удирдлагатай</i>	34	0.1%	11	0.0%	23	0.1%
Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	7,678,781.06	3.2%	6,924,482.05	3.7%	754,299.01	1.5%
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	5,999	13.3%	4,937	20.3%	1,062	5.2%
Иргэн	5,976	13.3%	4,916	20.2%	1,060	5.1%
Хуулийн этгээд	23	0.1%	21	0.1%	2	0.0%
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	231,982,558.30	96.8%	181,208,460.68	96.3%	50,774,097.62	98.5%
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	38,945	86.7%	19,421	79.7%	19,524	94.8%
Иргэн	38,905	86.6%	19,410	79.7%	19,495	94.7%
Хуулийн этгээд	40	0.1%	11	0.0%	29	0.1%
Хадгаламж эзэмшигчдийн насжилт	44,881	100.0%	24,326	100.0%	20,555	100.0%
18-35 насны	16,172	36.0%	10,812	44.4%	5,360	26.1%
36-45 насны	10,912	24.3%	5,007	20.6%	5,905	28.7%
46-55 насны	9,364	20.9%	4,499	18.5%	4,865	23.7%
56-аас дээш	8,433	18.8%	4,008	16.5%	4,425	21.5%
Хадгаламж эзэмшигчдийн боловсрол	44,881	100.0%	24,326	100.0%	20,555	100.0%
Дээд	19,425	43.3%	12,835	52.8%	6,590	32.1%
Тусгай дунд	6,189	13.8%	3,118	12.8%	3,071	14.9%
Бүрэн дунд	10,026	22.3%	4,088	16.8%	5,938	28.9%
Дунд	5,168	11.5%	1,756	7.2%	3,412	16.6%
Бага	4,073.00	9.1%	2,529	10.4%	1,544	7.5%

2024 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 44,944 хадгаламж эзэмшигчийн 239,661,339.36 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 54.2 хувь буюу 24,358 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 78.5 хувь буюу 188,132,942.73 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 45.8 хувь буюу 20,586 хадгаламж эзэмшигч орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 21.5 хувь буюу 51,528,396.63 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2024 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлийн нийт хөрөнгө 354,575,604.33 мянган төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.2 хувь буюу 51,908,699.10 мянган төгрөгөөр өсөж, банкны зах зээлийн 0.6 хувьтай тэнцэж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 13.3 хувийг хугацаагүй, 86.7 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.9 хувь буюу 44,881 нь хувь хүн (55.1 хувь буюу 24,743 нь эмэгтэй), 0.1 хувь буюу 63 нь хуулийн этгээд (0.1 хувь буюу 34 нь эмэгтэй удирдлагатай) байна.

Нэг хадгаламж эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,332.44 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,723.66 мянган төгрөг, орон нутагт 2,503.08 мянган төгрөг байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 20.9 хувь буюу 46,402,993.90 мянган төгрөгөөр, нийт татан төвлөрүүлсэн хадгаламж 12.5 хувь буюу 26,645,926.99 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 22.6 хувь буюу 10,519,952.42 мянган төгрөгөөр, нийт зарлага 12.5 хувь буюу 5,067,870.57 мянган

төгрөгөөр нэмэгдэж нийт цэвэр орлого 11,528,850.79 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай

зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай нийт ХЗХ-дын 59.0 хувь буюу 108 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны III улирал	2024 оны III улирал	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	302,666,905.23	354,575,604.33	51,908,699.10	17.2%
Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.6%		
Нийт зээл	221,997,781.97	268,400,775.86	46,402,993.90	20.9%
Банкны салбарт эзлэх хувь	0.8%	0.8%		
Нийт чанаргүй зээл	6,912,987.53	6,715,500.41	-197,487.12	-2.9%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.1%	2.5%	-0.6%	-19.7%
Банкны салбарт эзлэх хувь	0.3%	0.3%	0.0%	7.8%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	213,015,412.36	239,661,339.36	26,645,926.99	12.5%
Банкны салбарт эзлэх хувь	1.1%	1.0%		
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	27,209,177.46	28,643,912.57	1,434,735.12	5.3%
Нийт хоршоологчдын өмч	37,274,287.02	49,856,382.77	12,582,095.74	33.8%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	7,444,752.01	15,494,555.43	8,049,803.42	108.1%
Нийт орлого	46,464,543.77	56,984,496.20	10,519,952.42	22.6%
Нийт зарлага	40,387,774.84	45,455,645.41	5,067,870.57	12.5%
Цэвэр орлого, алдагдал	6,076,768.93	11,528,850.79	5,452,081.85	89.7%

2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 92 ХЗХ-ны нийт хөрөнгө 277,408,050.30 мянган төгрөг нь зах зээлийн 78.2 хувь, нийт зээл 204,797,519.71 мянган төгрөг нь зах зээлийн 76.3 хувь, нийт хадгаламж 188,132,942.73 мянган төгрөг нь зах зээлийн 78.5 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.4 хувь буюу 326,366.98 мянган төгрөгөөр буурч 5,670,148.06 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 2.8 хувийг эзэлж байна. Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 1.1 дахин буюу

7,976,073.36 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 24.5 хувь буюу 8,397,872.20 мянган төгрөгөөр, нийт зарлага 10.5 хувь буюу 3,204,440.52 мянган төгрөгөөр, цэвэр орлого 1.5 дахин буюу 5,193,431.68 мянган төгрөгөөр өсөж 8,769,485.41 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай Улаанбаатар хотын ХЗХ-дын 62.0 хувь буюу 57 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны III улирал	2024 оны III улирал	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	239,799,487.65	277,408,050.30	37,608,562.65	15.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	79.2%	78.2%	-1.0%	-1.3%
Нийт зээл	169,334,508.03	204,797,519.71	35,463,011.68	20.9%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	76.3%	76.3%	0.0%	0.0%
Нийт чанаргүй зээл	5,996,515.04	5,670,148.06	-326,366.98	-5.4%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	86.7%	84.4%	-2.3%	-2.7%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.5%	2.8%	-0.8%	-21.8%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	171,890,498.38	188,132,942.73	16,242,444.35	9.4%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	80.7%	78.5%	-2.2%	-2.7%

Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	20,002,750.53	20,584,973.24	582,222.71	2.9%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	73.5%	71.9%	-1.6%	-2.2%
Нийт хоршоологчдын өмч	26,901,292.10	37,610,567.66	10,709,275.56	39.8%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	72.2%	75.4%	3.3%	4.5%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	7,394,752.01	15,370,825.36	7,976,073.36	107.9%
Нийт орлого	34,221,230.88	42,619,103.08	8,397,872.20	24.5%
Нийт зарлага	30,645,177.14	33,849,617.66	3,204,440.52	10.5%
Цэвэр орлого, алдагдал	3,576,053.74	8,769,485.41	5,193,431.68	145.2%

2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 91 ХЗХ-ны нийт хөрөнгө 77,167,554.03 мянган төгрөг нь зах зээлийн 21.8 хувь, нийт зээлийн үлдэгдэл 63,603,256.15 мянган төгрөг нь зах зээлийн 23.7 хувь, нийт хадгаламж 51,528,396.63 мянган төгрөг нь зах зээлийн 21.5 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 17.3 хувь буюу 2,122,080.22 мянган төгрөгөөр, нийт зарлага 19.1 хувь буюу 1,863,430.05 мянган төгрөгөөр тус тус өсөж, нийт цэвэр орлого

2,759,365.37 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгосон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК, “Бүрэн скор ЗМС” ХХК-тай орон нутгийн ХЗХ-дын 56.0 хувь буюу 51 ХЗХ мэдээлэл өгөх, авах гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2023 оны III улирал	2024 оны III улирал	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Нийт хөрөнгө	62,867,417.57	77,167,554.03	14,300,136.45	22.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	20.8%	21.8%	1.0%	4.8%
Нийт зээл	52,663,273.94	63,603,256.15	10,939,982.22	20.8%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	23.7%	23.7%	0.0%	-0.1%
Нийт чанаргүй зээл	916,472.49	1,045,352.35	128,879.86	14.1%
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	13.3%	15.6%	2.3%	17.4%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.5%	0.5%	0.0%	-5.7%
Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж	41,124,913.99	51,528,396.63	10,403,482.64	25.3%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	19.3%	21.5%	2.2%	11.4%
Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө	7,206,426.93	8,058,939.34	852,512.41	11.8%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	26.5%	28.1%	1.6%	6.2%
Нийт хоршоологчдын өмч	10,372,994.93	12,245,815.11	1,872,820.19	18.1%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	27.8%	24.6%	-3.3%	-11.7%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	50,000.00	123,730.06	73,730.06	147.5%
Нийт орлого	12,243,312.90	14,365,393.12	2,122,080.22	17.3%
Нийт зарлага	9,742,597.70	11,606,027.75	1,863,430.05	19.1%
Цэвэр орлого, алдагдал	2,500,715.20	2,759,365.37	258,650.18	10.3%

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталсан. Журам шинэчлэн баталсантай холбоотойгоор хадгаламж болон зээлийг хүлээн зөвшөөрөх хэмжилтийн сууриуд, үнэ цэнийн өсөлт бууралт, хүүг хуримтлуулан

тооцох, шимтгэл хураамжийг хойшлуулан бүртгэх, тэнцлээс хасах, тэнцлээс хассан зээлийн орлогыг хүлээн зөвшөөрөх, эрсдэлийн санг СТОУС-ын дагуу ангилах, бүртгэлийн арга хандлагыг нарийвчлан зохицуулж, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар, дансны жагсаалтыг шинээр боловсруулж, ерөнхий данс, үндсэн дансанд өөрчлөлт орсон тул дараах хүснэгтээр харуулав.


Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц (мянган төгрөгөөр)

ХӨРӨНГӨ	2023 оны III улирал		ХӨРӨНГӨ	2024 оны III улирал	
	Дүн	Хувь		Дүн	Хувь
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	298,531,780.46	98.6%	САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	345,324,059.66	97.4%
Мөнгөн хөрөнгө	54,748,269.21	18.1%	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	64,890,839.58	18.3%
Бэлэн мөнгө	3,540,133.50	1.2%	Бэлэн мөнгө	3,440,040.36	1.0%
Банкинд байршуулсан харилцах	9,870,945.90	3.3%	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	14,864,435.80	4.2%
Банкинд байршуулсан хадгаламж	41,337,189.82	12.6%	Банканд байршуулсан хадгаламж	42,784,447.75	12.1%
			Замд яваа мөнгө	9,168.47	-
			Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-
			Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулах тооцсон хүүгийн авлага	3,792,747.21	1.1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	700,000.00	0.2%			
Арилжааны үнэт цаас	700,000.00	0.2%			
Зээл (цэвэр)	217,139,572.91	71.7%	Зээл (цэвэр)	273,988,458.99	77.3%
Нийт зээл	221,997,781.97	73.3%	Нийт зээл	268,400,775.86	75.7%
Хэвийн зээл	206,410,597.33	68.2%	Хэвийн зээл	253,367,381.74	71.5%
Хугацаа хэтэрсэн зээл	8,674,197.11	2.9%	Хугацаа хэтэрсэн зээл	8,317,893.71	2.3%
Чанаргүй зээл	6,912,987.53	2.3%	Чанаргүй зээл	6,715,500.41	1.9%
			Зээлийн хойшлогдсон орлого	550	0.0%
			Зээлд хуримтлуулах тооцсон хүүгийн авлага	10,403,111.91	2.9%
(Зээлийн эрсдэлийн сан)	4,858,209.06	1.6%	(Зээлийн эрсдэлийн сан)	4,835,759.28	1.4%
			Зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	20,880.49	0.0%
Авлага	18,709,885.46	6.2%			
Байгууллага, хүмүүсээс авах авлага	7,245,232.64	2.4%			
Хуримтлуулах тооцсон хүүгийн авлага	11,464,652.82	3.8%			
Бусад эргэлтийн хөрөнгө	6,213,306.53	2.1%	Бусад санхүүгийн хөрөнгө	6,444,761.09	1.8%
Татварын авлага	10,117.12	0.0%	Дансны авлага (цэвэр)	1,844,752.57	0.5%
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	5,848,842.87	1.9%	Дансны авлага	1,844,752.57	0.5%
Дараа тайлангийн тооцоо	32,266.83	0.0%	Хувь хүнээс авах авлага	516,229.15	0.1%
Дугагдал, шамшигдал	25,073.17	0.0%	Хуулийн этгээдээс авах авлага	1,328,523.42	0.4%
Хангамжийн зүйлс	297,006.54	0.1%	(Авлагын эрсдэлийн сан)	-	0.0%
Салбар хоорондын авлага	-	0.0%	Холбоотой талаас авах авлага	3,797,892.43	1.1%
			Ажиллагчдаас авах авлага	29,082.11	0.0%
			Салбар хоорондын тооцоо	5,984.03	0.0%
			Өмчлөх бусад санхүүгийн хөрөнгө (цэврээр)	212,473.63	0.1%

			Бусад	554,576.32	0.2%
Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр)	1,020,746.35	0.3%			
Өмчлөх бусад хөрөнгө	1,061,035.40	0.4%			
(Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)	40,289.05	0.0%			
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	4,135,124.77	1.4%	САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ	9,251,544.67	2.6%
Үндсэн хөрөнгө (цэвэр)	3,969,905.69	1.3%	Татварын авлага	432,818.21	0.1%
Биет бус хөрөнгө	149,716.39	0.0%	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага	144.99	0.0%
Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	15,502.69	0.0%	Урьдчилж төлсөн зардал тооцоо	3,248,688.89	0.9%
			Бараа материал	220,482.54	0.1%
			Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	634,006.79	0.2%
			Бусад санхүүгийн бус хөрөнгө	159,767.88	0.0%
			Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө (цэврээр)	-	0.0%
			Үндсэн хөрөнгө (цэврээр)	4,386,776.41	1.2%
			Биет бус хөрөнгө (цэврээр)	168,858.96	0.0%
ХӨРӨНГИЙН ДҮН	302,666,905.23	100.0%	ХӨРӨНГИЙН ДҮН	354,575,604.33	100.0%


2024 оны 3 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 354,575,604.33 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.2 хувь буюу 51,908,699.10 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 97.4 хувийг санхүүгийн хөрөнгө, 2.6 хувийг санхүүгийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 18.3 хувийг, цэвэр зээл 77.3 хувийг тус тус эзэлж байна. Зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.2 хувиар өссөн байна.

Зураг 4: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс (мянган төгрөгөөр)




Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 20.9 хувь буюу 46,402,993.90 мянган төгрөгөөр өсөж 268,400,775.86 мянган төгрөгт хүрсэн бөгөөд 4,835,759.28 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна. Харин хугацаа хэтэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.1 хувь буюу 356,303.40 мянган төгрөгөөр буурч 8,317,893.71 мянган төгрөг, мөн чанаргүй зээл 2.9 хувь буюу 197,487.12 мянган төгрөгөөр буурч 6,715,500.41 мянган төгрөг болсон үзүүлэлттэй байна.

График б: Нийт хөрөнгийн бүтэц



ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад 2022 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар буурч хөрөнгийн хэмжээ дунджаар 10.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт (тэрбум төгрөгөөр)




3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 207,976,986.23 мянган төгрөг ба зах зээлийн нийт хөрөнгийн 58.7 хувийг, гишүүдийн тоо 19,450 байгаа нь нийт гишүүдийн 26.0 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	207,976,986.23	58.7%	19,450	26.0%
2	1,000,000.0 -10,000,000.0	33	110,636,543.58	31.2%	29,735	39.7%
3	500,000.0-1,000,000.0	23	16,751,991.53	4.7%	9,308	12.4%
4	100,000.0-500,000.0	69	15,967,464.24	4.5%	12,126	16.2%
5	50,000.0-100,000.0	35	2,754,149.58	0.8%	3,167	4.2%
6	10,000.0-50,000.0	16	473,886.11	0.1%	955	1.3%
7	10,000.0 хүртэл	3	14,583.05	0.00%	106	0.1%
Нийт дүн		183	354,575,604.33	100.0%	74,847	100.0%



3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 268,400,775.86 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 75.7 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 273,988,458.99 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 77.3 хувийг тус тус эзэлж байна. Нягтлан бодох бүртгэлийн журам шинэчлэгдсэнээр цэвэр зээлийн үндсэн дансанд хамаарах бусад нэрийн дансуудыг нэмэгдсэнээр тооцоолсон болно.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.34 хувь, тайлант хугацаанд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2.17 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 34 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 88.6 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар (мянган төгрөгөөр)

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	34	237,909,853.45	88.6%
2	500,000.0-1,000,000.0	19	12,774,815.59	4.8%
3	100,000.0-500,000.0	66	14,546,105.12	5.4%
4	50,000.0-100,000.0	31	2,250,094.52	0.8%
5	10,000.0-50,000.0	28	908,972.34	0.3%
6	10,000.0 хүртэл	4	10,934.85	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	1	-	-
Нийт дүн		183	268,400,775.86	100%

3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл (мянган төгрөгөөр)


Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Нийт	30,328	100.0%	268,400,775.86	100.0%
Хэвийн	28,132	92.8%	253,367,381.74	94.4%
Хугацаа хэтэрсэн	837	2.8%	8,317,893.71	3.1%
Чанаргүй	1,359	4.5%	6,715,500.41	2.5%
<i>Хэвийн бус</i>	458	33.7%	2,067,442.35	30.8%
<i>Эргэлзээтэй</i>	316	23.3%	1,712,774.14	25.5%
<i>Муу</i>	585	43.0%	2,935,283.92	43.7%

2024 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 94.4 хувь буюу 253,367,381.74 мянган төгрөгийг хэвийн зээл, 3.1 хувь буюу 8,317,893.71 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 2.5 хувь буюу 6,715,500.41 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 15,033,394.12 мянган төгрөгийн үлдэгдэлд 32.2 хувь буюу 4,835,759.28 мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна. Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.8 хувийг хэвийн, 2.8 хувийг хугацаа хэтэрсэн, 4.5 хувийг чанаргүй зээлдэгч эзэлж байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,359 зээлдэгчийн 6,715,500.41 мянган төгрөгийн үлдэгдлийн 30.8 хувийг

хэвийн бус, 25.5 хувийг эргэлзээтэй, 43.7 хувийг муу зээлийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 пунктээр өсөж 94.4 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.8 пунктээр буурч 3.1 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.6 пунктээр буурч 2.5 хувь болсон үзүүлэлттэй байна.

График 8: Зээлийн чанар



Хүснэгт 13: Зээлийн ангиллын мэдээлэл хот, орон нутгаар (мянган төгрөгөөр)

Зээлийн ангиллын мэдээлэл	Улаанбаатар хот			Орон нутаг		
	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Хувь	Нийт дүнд эзлэх хувь
Нийт	204,797,519.71	100.0%	76.3%	63,603,256.15	100.0%	23.7%
Хэвийн	192,850,069.47	94.2%	76.1%	60,517,312.27	95.1%	23.9%
Хугацаа хэтэрсэн	6,277,302.19	3.1%	75.5%	2,040,591.52	3.2%	24.5%
